



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2022 оны 12 сарын 07 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Аудитын сэдэв батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, 24 дүгээр зүйлийн 24.8.3 дахь заалтыг тус тус үндэслэн Төсвийн байнгын хорооноос **ТОГТООХ** нь:

1.Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын сэдвийг хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоолын хавсралтад заасан аудитыг хугацаанд нь гүйцэтгэж, аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, гишүүдэд хүргүүлж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудитор (Д.Занданбат)-т үүрэг болгосугай.

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Г.ТЭМҮҮЛЭН

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны
2022 оны 2-дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН 2023 ОНД ГҮЙЦЭТГЭХ АУДИТЫН СЭДЭВ

№	Аудитын сэдэв	Хамрах хүрээ	Аудит хийх хугацаа	Аудитын тайлан дүгнэлтийг хүргүүлэх
Нэг. Хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх аудитын сэдэв				
1	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл	МУ-ын Засгийн газар Сангийн яам	2023.04.14-06.10	Улсын Их Хурал
2	Сангийн яамны 2022 оны санхүүгийн тайланд аудит хийх	Сангийн яам	2023.04.17-05.05	Төсвийн ерөнхийлөн захирагч
3	Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх	Төсвийн ерөнхийлөн захирагчид	2023.03.24-04.25	Төсвийн ерөнхийлөн захирагч
4	Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх	Төсвийн төвлөрүүлэн захирагчид	2023.02.27-03.25	Төсвийн төвлөрүүлэн захирагч
5	Засгийн газрын тусгай сангийн санхүүгийн тайланд аудит хийх	Засгийн газрын тусгай сангууд	2023.01.02-02.25	Төсвийн ерөнхийлөн захирагч
6	Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд аудит хийх	Холбогдох аж ахуйн нэгжүүд	2023.02.15-03.15	Төсвийн ерөнхийлөн захирагч
7	Төсөл, хөтөлбөрүүдийн санхүүгийн тайланд аудит хийх	Төсөл, хөтөлбөрүүд	2023.01.02-02.25	Төсвийн ерөнхийлөн захирагч
8	Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд аудит хийх	Төсвийн шууд захирагчид	2023.01.02-02.25	Төсвийн шууд захирагч

9	Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх	МУ-ын Засгийн газар УУХҮЯ, АМГТГ холбогдох гэрээлэгч компаниуд	2023.01.16-12.15	Төсвийн ерөнхийлөн захирагч
10	Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх	МУ-ын Засгийн газар УУХҮЯ АМГТГ, холбогдох гэрээлэгч компаниуд	2023.01.16-12.15	Төсвийн ерөнхийлөн захирагч
11	Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх	МУ-ын Засгийн газар Сангийн яам	2023.08.25-10.15	Төсвийн байнгын хороо
12	Улсын хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүн	МУ-ын Засгийн газар Сангийн яам	2023.01.05-03.15	Төсвийн байнгын хороо
13	Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт	Сангийн яам Эдийн засгийн хөгжлийн яам	2023.01.16-12.15	Төсвийн байнгын хороо Эдийн засгийн байнгын хороо
14	Улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж баталсан төсөл арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэл зардалд дүгнэлт гаргах	Сангийн яам	2023.01.16-12.15	Төсвийн байнгын хороо
Хоёр. Бодлогоор гүйцэтгэх аудитын сэдэв				
15	Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө	МУ-ын Засгийн газар ХНХЯ, холбогдох байгууллагууд	2023.09.15-12.15	Төсвийн байнгын хороо, Нийгмийн бодлогын байнгын хороо

16	Үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн болон валютын ханшны өөрчлөлтийг тогтворжуулах бодлогын үр нөлөө	МУ-ын Засгийн газар Монгол банк Сангийн яам	2023.04.05-06.30	Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо
17	Монгол-Оросын “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн үйл ажиллагааны үр дүн, нийгэм эдийн засагт үзүүлж буй үр нөлөө, үр ашиг	МУ-ын Засгийн газар холбогдох байгууллагууд	2023.01.16-12.15	Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо
18	Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө	МУ-ын Засгийн газар ЭМЯ, ЭМДЕГ	2023.01.05-06.30	Төсвийн байнгын хороо, Нийгмийн бодлогын байнгын хороо
19	Татан буугдсан банктai холбоотой шийдвэрүүдийн хэрэгжилт, үр нөлөө	МУ-ын Засгийн газар Монгол банк Сангийн яам	2023.09.18-12.08	Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо
20	Монгол Улсын Засгийн газраас “Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний явц, үр дүн	МУ-ын Засгийн газар холбогдох байгууллагууд	2023.08.15-12.01	Төсвийн байнгын хороо, Инновац, цахим бодлогын байнгын хороо
21	Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэл	Сангийн яам, УУХҮЯ холбогдох байгууллагууд	2023.03.15-06.20	Төсвийн байнгын хороо
22	Төрөөс шинжлэх ухаан, технологийн салбарын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт, үр нөлөө	БШУЯ, ШУА, холбогдох байгууллагууд	2023.08.15-11.30	Төсвийн байнгын хороо, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо
23	Хөгжлийн банкны үйл ажиллагааны үр нөлөө, үр ашиг	МУ-ын Засгийн газар Сангийн яам Хөгжлийн банк	2023.09-15-12.15	Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо
24	Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж	Сангийн яам ХХААХҮЯ, холбогдох байгууллагууд	2023.06.20-09.20	Төсвийн байнгын хороо Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо

25	Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөө	Сангийн яам холбогдох байгууллагууд	2023.04.10-07.20	Төсвийн байнгын хороо
Гурав. Өмнөх оноос үргэлжлүүлэн гүйцэтгэх аудитын сэдэв				
26	Оюутолгой төсөлд оруулсан хөрөнгө, оруулалт, санхүүжилтийн зарцуулалт, үр нөлөө	МУ-ын Засгийн газар Сангийн яам	2023.01.02-09.29	Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо
27	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018-2022 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлт	Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Уул уурхайн яам	2023.01.05-04.20	Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо
28	Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгийн үр дүн	Сангийн яам, ЭЗХЯ, ЗТХЯ холбогдох байгууллагууд	2023.01.05-04.20	Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо

-----oOo-----